

Та өвчтэй бол гэртээ үлд

Корона вирусын тархалтыг багасгахын тулд бид хамтдаа бүхнийг хийе

Шинэ корона вирус нь ердийн ханиад эсвэл томууг санагдуулах covid-19 гэх өвчнөөр өвдүүлж болно. Шинж тэмдэг илэрсэн ихэнх хүмүүс хүндээр өвчлөхгүй ч өндөр настай, өвчтэй хүний хувьд энэ өвчин аюултай байж болно. Covid-19 өвчин нь үүгээр өвчилсөн хүн ханиалгах эсвэл найтаалгах үед голдуу халдана.

Та өвчтэй бол гэртээ үлд

Та халуурч, ханиалгаж, нус гоожиж эсвэл хоолой өвдөж байгаа бол гэртээ үлдэж, гэрийнхнээсээ өөр хүмүүстэй уулзахаас залсхийх хэрэгтэй. Та өөрөө өөртөө бага зэрэг өвчтэй санагдсан ч гэртээ үлдэх хэрэгтэй. Та бүрэн эрүүл болоод хоёр хоног өнгөртөл гэртээ байх хэрэгтэй. Ингэснээр та бусдыг халдварлуулахгүй.

Өндөр настай ба хүнд өвчтэй хүнийг хамгаал

Өндөр настай хүн хүндээр өвчлөх эрсдэл нь өндөр. Хүнд өвчтэй хүн бас адил. Тиймд та тэдэнтэй уулзах эсвэл тэдэн дээр очихоос зайлсхийх нь чухал. Тэдэнтэй үүний оронд утсаар ярь.

Өвчлөхгүйн тулд та өөрөө юу хийж чадах вэ?

- Гараа ойр ойрхон, савантай усаар, сайтар угаа. Савантай ус байхгүй бол гарын ариутгагч хэрэглэ.
- Нүд, хамар ба амаа оролдохгүй байхыг хичээ.

- Ханиалгаж, найтааж буй хүнээс зай барьж, гараас нь барихаас зайлсхий.

Та хэзээ ба хаана эмнэлгийн тусламж хайх вэ?

Covid-19 өвчнөөр өвчлөгсдийн ихэнх нь эмнэлгийн тусламж хайх хэрэггүй, учир нь тэдний зовиур аяндаа арилдаг. Таны бие улам муудвал эсвэл таны амьсгал амарч байх үед тань ч гэсэн зовиуртай байвал 1177 утас руу залга. Тэгвэл сувилагч танд зөв үйлчилгээг зөв газраас олоход тань тусална. Амь насанд аюултай нөхцөлд заавал 112 дугаар руу залгаарай.

Утсаар эмнэлгийн зөвлөгөө авбал дараах хэлээр авч болно:

- Англи хэл – 1177 утас руу өдөр бүр 24 цагаар
- Финланд хэл – 1177 утас руу ажлын өдөр 8–12 цагт
- Араб хэл – 08-123 130 80 утас руу өдөр бүр 8–22 цагт
- Сомали хэл – 08-123 130 90 утас руу ажлын өдөр 8–17 цагт
- Перс хэл – 08-123 130 87 утас руу ажлын өдөр 8–17 цагт

Нэмэлт мэдээлэл 1177.se цахим хуудас дээр бий, мөн танд covid-19 өвчний талаар ерөнхий асуулт бий бол 113 13 утас руу залгана уу.